



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар A/254

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Оточ овогтой Жамсрангийн Цолмон (СТ72062221)-ийн эзэмшлийн Хэрлэн сумын 4 дүгээр баг (Сариг), Тээвэрчид гудамж Б-20-20 тоотод байршилтай гэр булийн хэрэгцээний зориулалттай 1400м<sup>2</sup> газраас иргэн Боржигин овогтой Батмөнхийн Мөнх-Эрдэнэ (СЭ99022131)-д 700м<sup>2</sup> газрыг 9 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.
- Иргэн Боржигин овогтой Батмөнхийн Мөнх-Эрдэнэ эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.
- Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгоч гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү)-т үүрэг болгосугай.
- Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Б.Мөнх-Эрдэнэд үүрэг болгосугай.
- Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/358 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231011554